

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2017 ОНЫ 5 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2017.05.19

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

1.1. Аймаг сумын Засаг даргын захирамжын хэрэгжилтийн талаар:

2017.04.20-нд хийгдсэн ГЭЗХХШ хурлаас гарсан шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх захирамж гаргуулахаар **9** иргэн, хуулийн этгээдийн захирамжийн төслийг боловсруулан хүргүүллээ.

2017.05.18-нд ГЭЗХХШ комиссын хурлаар нийт **81** иргэн хуулийн этгээдийн газар эзэмшил, өмчлөлтэй холбоотой асуудлаар хуралдаж аймгийн Засаг даргын захирамжийн төсөлд **47** иргэн, хуулийн этгээд, Дархан сумын Засаг даргын захирамжинд **11** иргэний захирамж гаргуулахаар төслийг бэлтгээд байна.

Дархан сумын Засаг даргын захирамжаар Дархан суманд газар өмчилсөн **31**, хамтран өмчлөгч хасуулсан **18** иргэний бүртгэлийн мэдээллийн санд бүртгэн УБХ-д бүртгүүлэхээр материалыг иргэнд гарган өгч үйлчилсэн.

Мөн аймгийн ЗД-ын 2017 оны А/130 дугаар захирамжаар зарласан дуудлага худалдааг 2017 оны 05 дугаар 08-ны 11 цагт зохион байгууллаа. Дуудлага худалдааг нийт **9** нэгж талбар дээр зарласнаас 1 оролцогч оролцсон учир дуудлага худалдаа явагдаагүй.

1.2. Газрын төлбөр барагдуулалтын талаар

2017 оны 05 дугаар сарын 19-ны байдлаар газрын төлбөрт өссөн дүнгээрээ **217,8** сая төгрөг төвлөрсөн байна. Дархан гурил тэжээл ХХК-аас газрын төлбөрт **17,8** сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар шүүхийн шийдвэр эцэслэн гарахаар болсон.

1.3. Өргөдөл, албан бичгийн хариу, тайлан мэдээ гаргаж хүргүүлсэн талаар”

Дархан сумын 7-р баг Тээвэрчидийн 6-16 тоот, 6 баг Ногоон зоорийн газарт хээрийн судалгаа хийж газар дээр нь очиж ажилласан.

Хонгор, Шарын гол, Орхон сумдад ОНТХГ нутгийн судалгааг гаргаж ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлэв.

Газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтыг сайжруулах зорилгоор, удаа дараа гэрээний хугацаа сунгасан газруудтай „Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, Газар ашиглалтын төлөвлөгөө,, гаргуулж аван хяналт тавьж байна. Энэ долоо хоногт **5** иргэн, **7** аж ахуйн нэгж газар ашиглалтын төлөвлөгөөгөө ирүүлж, гэрээ байгууллаа.

Бусад аймаг сумын нутагт газар өмчлөх эрхээ эдлэхээр хүсэлт гаргасан **32** иргэнд Дархан суманд газар өмчлөөгүй лавлагааг гаргаж үйлчилсэн. Нийт **25** өргөдөл, **19** албан бичиг ирсэнийг бүртгэж, **26** албан бичиг төлөвлөж явуулсан байна.

Өссөн дүнгээр албанд нийт **505** албан бичиг ирсэний **226** албан бичгийг хяналтанд авч үүнээс **201** албан бичгийн хагиуг хүргүүлсэн байна. Хугацаа болоогүй **23**, хугацаа хэтэрсэн **2**.

1.4. Кадастр, кадастрын зураг гаргаж үйлчилсэн, хэмжилт хийсэн, магадлан хэмжилт хийсэн талаар:

Гэр бүлийн хэрэгцээний газраа өмчилсөн , эзэмших эрхийн гэрээ хийсэн, худалдсан, бэлэглэсэн, хуваасан нийт **91** иргэн, аж ахуй нэгжийн кадастрын зургийг гаргаж өгсөн. Дархан сум 6-р багийн Ханжаргалангийн 2-18 тоотод оршин суугч иргэн Н.Нарантуяа, 7-р багийн Сэргэлэнгийн 3-59а тоотод оршин суугч иргэн Ц.Наранхүү, “ЭМА ТРЕЙД” ХХК-ны гаргасан өргөдөл хүсэлтийн дагуу газар дээр нь хяналтын хэмжилт хийлээ.

1.5. Мэдээлэл технологийн чиглэлээр хийгдсэн ажлын талаар.

Байгууллагын цахим болон фэйсбүүк хуудсанд:

- Газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн сонорт
- "Нэгдсэн бодлого - нэгдмэл тогтолцоо" газрын багц хуулийн хэлэлцүүлэг
- Мэндчилгээ
- Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг хүлээн авч байна.
- Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм, барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэгдэн батлагдлаа.
- Барилгын хөгжлийн төв 2017 он
- Орхон аймаг " Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-гөө сайн баримтлан ажиллаж байна.
- Дархан-уул аймагт 2017 онд төсвийн хөрөнгө оруулалтаар 18.1 тэрбум төгрөгийн ажил хийгдэнэ
- Газрын харилцааны ажилтны өдөр тохиож байна.
- 2017 оны 4 дүгээр сард хийсэн ажлын тайлан
- 2017 оны 4-р сарын 4 дүгээр 7 хоногийн ажлын тайлан мэдээнүүдийг оруулсан.
- Байгууллагын серверийг хуучин байсан агуулахын өрөөнөөс шилжүүлж стандартад нийцүүлэн суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн
- “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төслийн нээлтийн семинар боллоо
- “хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорил” аймгийн ГХБХБГ-т явагдлаа
- 2017 оны 05 дугаар сарын 1 дүгээр 7 хоногийн ажлын тайлан
- Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм, барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэгдэн батлагдлаа зэрэг мэдээллүүдийг оруулсан.
- Байгууллагын серверийг шилжүүлсэнтэй холбогдуулан шилэн кабель болон сүлжээний кабелиудыг цэгцлэх ажлыг хийж, хэвийн ажиллагаанд оруулсан.
- Байгууллагын Дипломат болон албан /ногоон/ паспорт бүхий албан хаагчдын судалгаа гаргаж Төрийн захиргаа удирдлагын хэлтэс хүргүүлсэн. Мөн Дархан-Уул аймгийн Хонгор, Орхон, Шарын гол сумдын Засаг дарга нарт сумдын даамлуудын ажлын байрны тодорхойлолтод нэмэлт оруулах тухай, Газрын даамлуудыг сургалтанд хамруулах тухай албан бичгүүдийг хүргүүлсэн.
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны 15 санал асуулгыг боловсруулж байгууллагын цахим хуудас болон facebook хуудсаар дамжуулан 45 хоногийн хугацаанд авч эхлээд байна.

1.6.Бусад ажлын талаар:

Газрын харилцааны өдрийг угтаж УБ хотод зохион байгуулагдсан спортын арга хэмжээ болон хуулийн хэлэлцүүлэгт хамт олноороо оролцлоо. Аймгийн ХШҮ дотоод аудитын газраас хийгдсэн сургалтанд байгууллагын ХШҮ баг сургалтанд хамрагдсан Улаанбаатар хотын авто машингүй өдрийг тохиолдуулан хамт олноороо дугуйн аялалыг амжилттай зохион байгуулсан.

ИХАШШ-д иргэн Ш.Оюунгэрэлийн нэхэмжлэлтэй орц, гарцын асуудал шийдвэрлүүлэх хэргийн шүүх хурал 2017.05.08-ны өдөр болж, Тэс петролиум ХХК шүүгчээс татгалзах хүсэлт ирүүлж түр хугацаагаар хойшлогдсон.

Аймгийн ХШҮ дотоот аудитын газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу дотооддоо хяналт шалгалт хийж, үр дүнг хүргүүлсэн.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2.1.Хот байгуулалтын талаар:

- “Гор газ” ХХК-н АХЦС-н эскиз хянаж хүргүүлэв
- БХБЯ уруу орон сууцны судалгаа гаргаж хэвлэмэл болон файлаар хүргүүлж албан бичгийг хаав
- Аймгийн ИТХ-н хуралд барилга байгууламжийн талаар тавих танилцуулга хийв
- "Нарны хүүхдүүд асрамжийн төв"-н 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын эскиз хянаж хэлтсийн дарга, ерөнхий архитектор руу хүргүүлэв
- “Дархан-Өргөө” ХХК . Ферросилокон хайлш үйлдвэрлэх үйлдвэрийн эскиз зураг хянаж хэлтсийн дарга, ерөнхий архитектор руу хүргүүлэв
- “Дархан-Өргөө” ХХК-н Ферросилокон хайлш үйлдвэрлэх үйлдвэрийн барилгад архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж өгөв
- Дуудлага худалдааны байршилтын зургийн асуудлаар дулааны инженертэй газар дээр нь явж зөвлөлдөв /6 байршилд/
- Гамшгийн үед цугларах цугларалтын байршилтын зураг зурж хийж аймгийн ОБГ-т танилцуулсан
- ОБЕГ-с ирүүлсэн “Нийтийн орон сууц, олон нийтийн зориулалттай барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлын үзлэг шалгалт явуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг хүчитгэх, шинэчилж барих арга хэмжээ” удирдамжийн дагуу аймгийн МХГ-н мэргэжилтнүүд, хотоос ирсэн ОБЕГ-с ирсэн төлөөллийн хамт хамтарч ажилласан.
- Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангасан.
- Биеийн тамирын шалгалт, сорил авсан дүнг нэгтгэж soril.mn сайтад зааврын дагуу шивж байршуулсан
- “Тэс петролиум” ХХК –н Хонгор сум 3-р баг Салхит тосгонд, Хонгор сум 1-р баг Эрдэнэтийн уулзвар, постын цаана байрлалтай шатахуун түгээх станцын барилгуудад архитектур төлөвлөлтийн даалгавар бичиж хянуулахаар хүргүүлсэн
- Дархан сумын 3-р багийн 2-р гудамж, 2-р багийн 7-р гудамж, Дархан сум 10-р багт байрлалтай авто зогсоолын байршилтын зураг хийж хянуулсан
- ГЗБГЗЗГ-т ерөнхий төлөвлөгөөний судалгааг CD-гээр хүргүүлэв
- БХБЯ, ГЗБГЗЗГ, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх БАЗ-өөс ирсэн судалгааг хийж байна

- Тогтвортой амьжиргаа-3 төслийн хүрээнд бүх багуудад хийгдэх /гэр хороололд/ тохижилт засварын ажлын байршилтыг тодорхойлж зураг /14ш/ хийж өгсөн.
- “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд хийж байгаа Дархан сумын 1.2.3-р багт гэр хорооллын дундхи гудамжинд сайжруулах авто зам, 4.8.10-р багийн орон сууцны дундах авто зогсоол, явган замын байршилтын зураг хийж хэлтсийн даргаар хянуулсан
- “Гор Газ” ХХК-ны Хонгор сум, Дархан сумуудад барих АХЦС-н барилгад Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж хянуулахаар өгсөн.
Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх БАЗ-өөс ирсэн судалгааны талаар ИШС-ны байгууллагатай хурал зохион байгуулж судалгааг цуглуулж байна

2.2. Барилга угсралтын талаар :

- Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн Иргэн Б.Бадамсэд-н оффис, үйлчилгээний барилга, “ДСЦТС” ХК-ны 54 айлын орон сууц, “Содон сэтгэмж” ХХК-н үйлчилгээтэй орон сууц, “Минж Проперти” ХХК-ны 70 айлын нийтийн орон сууцны барилгын техникийн бичиг баримтуудыг хянан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч зөвшөөрлийг олгосон.
- Дархан-Уул аймаг, Дархан сум 5-р багийн Хүүхэд хөгжлийн ордны барилгыг ашиглалтад оруулах хүсэлтийн дагуу комиссыг зохион байгуулж ажиллан комиссын гишүүдийн шийдвэрийг үндэслэн ашиглалтад хүлээн авсан.
- Дархан-Уул аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд Иргэн Б.Мөнхтөрийн үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулсан эсэх лавлагааг гаргаж хүргүүлсэн.
- Барилга угсралтын тусгай зөвшөөрөл шинээр хүссэн “Асгат Ярх” ХХК-д тодорхойлолтыг гаргаж хүргүүлсэн.
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 8-р багт байршилтай Иргэн И.Түмэндэмбэрэлийн 25 айлын нийтийн орон сууцны барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүсэлтийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг судалж барилга угсралтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох боломжгүй тухай хариуг албан тоотоор хүргүүлсэн.
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р баг, 2-р хороололд байршилтай Иргэн Б.Мөнхтөрийн зорьтой үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах хүсэлтийн дагуу барилга байгууламжийг газар дээр нь очиж үзэхэд гадна тохижилт, гадна бетоны хаяавч, дээвэр зэрэг ажлууд дутуу хийгдсэн тул барилга ашиглалтад оруулах боломжгүй гэсэн хариу албан тоотоор хүргүүлсэн.
- “Болор Эрхэст цамхаг” ХХК-ны шинээр барилга угсралтын тусгай зөвшөөрөл хүссэний дагуу барилгын техникийн бичиг баримтыг судалж үзэн БХТөвд тодорхойлолт гаргаж өгсөн.
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 8-р багт Иргэн О.Мөнхцэцэгийн үйлчилгээний зориулалттай барилгын өргөтгөлийн барилга, Дархан-Уул аймаг, Дархан сум Өмнөд үйлдвэрийн районд байршилтай Хүдэр баяжуулах үйлдвэр “HSMG” ХХК нь барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авалгүй барилга угсралтын явуулсан тул мэдэгдэх хуудас өгч хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Дархан-Уул аймгийн Шарын гол суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 150 хүүхдийн дотуур байрны барилга угсралтын ажлын явцыг Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран шалгахад захиалагч гүйцэтгэгчийн хоорондын гэрээний хугацаа дууссан, барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авалгүй барилгын ажил гүйцэтгэж байгаа зөрчилтэй байсан тул Мэргэжлийн хяналтын барилгын техник хяналтын улсын байцаагч С.Цэвэлравжаа тус барилгыг лацдан барилга угсралтын ажлыг зогсоосон.

2.3. Инженерийн шугам сүлжээний ажлын талаар:

- Дуудлага худалдааны болон төсөл сонгон шалгаруулалтаар олгогдох газрын байршлын зурагт зурагт зөвшилцөл хийлгэж байна.
 - Дуудлага худалдаанд орох газруудын байршилтын зурагт цахилгаан, холбоо, дулааны шугамын тодруулалтыг дахин хийж даргад танилцуулав.
 - “ДДС” ТӨХК-с техникийн нөхцөл авах хүсэлт гаргасан 5 иргэн, ААНБ-д тодруулах хуудас гаргаж өгөв
 - УБ хотод явсан ажлын тайлан гаргасан.
 - “Дархан ус суваг” ТӨХК-с техникийн нөхцөл авах хүсэлт гаргасан 3 иргэн, ААНБ-д тодруулах хуудас гаргаж өгөв
 - “ЦДҮС” ХК-с ирүүлсэн албан бичгийн дагуу газар зохион байгуулагч, геодезийн инженертэй хамтран Бурхант ба Давхар дэд станцуудын газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцлаа.
 - Хабитат, Мангиртын гэр хороололд орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн гудамжны гэрэлтүүлгийн шугамын гүйцэтгэлийг хүлээн авч байр зүйн зурагт оруулсан
 - Дархан сум. 14-р баг 2-р хороололд баригдсан иргэн Болдбаатарын хашаа байшин, гадуур нь явсан дулааны шугамын трассыг хэмжилт хийлгэн байр зүйн зурагт орууллаа.
 - Дархан сум. 8-р багт баригдсан 6-р цэцэрлэгийн барилгын мэдээллийг байр зүйн зурагт гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг үндэслэн оруулж өгөв
 - Дархан сум. 14-р баг иргэн Ж.Батцолмонгийн авто засвар үйлчилгээний барилгын ерөнхий төлөвлөгөөний зурагт хяналт хийсэн.
 - Инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн хөтлөлт хийх ажил түр хойшлогдов /сүлжээ холбогдох хүртэл/
 - Иргэн Цэцгээгийн “Маргад” худалдааны төвийн барилгын 0,4кВ кабель шугамын гүйцэтгэлийг хүлээн авч байр зүйн зурагт оруулсан
 - Шарын гол суманд ажиллав.
- Инженерийн шугам сүлжээний байгууллагууд болон Захирагчийн ажлын албанд албан бичиг хүргүүлсэн.

2.4. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр:

- Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх талаар “Нийтийн орон сууц”-ны барилгын нэг маягийн зургийг “Дархан Дизайн” ХХК-аар хийлгэхээр СӨХ-ны дарга нартай тохиролцож ажлыг эхлүүллээ.
- Хүүхэд хөгжлийн ордны барилга ашиглалтад оруулах комиссын бүрэлдхүүнд орж ажилласан.

- “Халнит” ХХК, “Хатан хүсэл” ХХК, “Гэрэлт гартаам” ХХК- уудад барилга угсралтын тусгай зөвшөөрөл сунгахаар “Шарын гол” ХК-д “Эрчим хүчний цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ”-ний тусгай зөвшөөрлийн тодорхойлолтыг материал, холбогдох бичиг баримттай танилцаж гаргаж өгөв.
- ДаШУТИС-ийн өргөтгөлийн барилгын улсын комиссын хурлын тэмдэглэлийг гаргаж үүрэг даалгаврын биелэлт, комиссийн актыг бичиж комиссийн дарга болон хэлтсийн даргад танилцуулав.
- Барилга, захиалагчийн албанд барилга материалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-н судалгаа, мэдээллийг гаргаж хүргүүлсэн
- Сүүлийн 5 жилд ашиглалтад орсон 47 барилгын гадна тохижилтын ажлыг хийж дуусгасан талаарх мэдээллийг боловсруулж байна.
- Барилгын хөгжлийн төв, БСШУЯ, гүйцэтгэгч “Хатиган болор” ХХКд Дархан сумын 1-р багт баригдсан цэцэрлэгийн барилгын уурын зуухны тогоог засварлах тухай албан бичиг хүргүүлсэн
- “Газрын удирдлагын хэлтсийн даргад 2012-2017 онд баригдсан барилгуудын судалгаа, мэргэжилтэн Анхбаярт нийтийн орон сууцны барилгын судалгаа тус тус гаргаж өгсөн
- Засгийн газрын 2017 оны 68-р тогтоолтой танилцсан
- “Мөнх од цацрал” ХХК-ийн мэдээллийн дагуу МХГ-ын барилга техник хяналтын улсын байцаагч С.Цэвэлправжаатай хамтран “Өсөх баян бүрд хаус” ХХК-ийн замын хавтан, тохижилтын хийцийн үйлдвэртэй танилцаж зөрчлийг арилгах хүртэл ажлын актаар зогсоох шийдвэр гаргаж ажиллав
- Монголын барилга материалын үйлдвэрлэгчдийн холбоотой зөвлөлдсөний дагуу Удирдах зөвлөлийн мэргэжилтнүүд Дархан-Уул аймагт вакуум цонх, зам хавтан тохижилтын хийц, төмөр бетон үйлдвэрлэл эрхэлж байгаа 7 ААНБ-ын ажил байдал, технологитой танилцаж газар дээр нь зөвлөгөө өгч ажиллахаар тохиролцлоо.
- “Гасба” ХХК-ийн Барилга угсралтын 3.2.3 заалтын дагуу бүрдүүлсэн техникийн бичиг баримт хийж гүйцэтгэсэн ажлын тайланг үндэслэн Эрчим хүчний хөгжлийн төвд тодорхойлолт гаргаж өгөв.

2.5. Бусад ажилын талаа:

- Гадна орчны цэвэрлэгээнд хамрагдав
- Биеийн тамирын Сорилын Шалгалт өгсөн
- ГЗБГЗЗГ-с ирсэн шалгалтад бүгд хамрагдсан
- Дугуйн аялалд оролцоцгоов

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН

С.БАТБИЛЭГ